



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/827

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, 4 дүгээр зүйлийн 4.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 4/03 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “COVID-19”-ийн цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, вакцинжуулалтын үйл ажиллагаатай холбоотой үүссэн өрийг барагдуулахаар Булган сумын Засаг даргын Тамгын газарт 10.0 сая төгрөгийн, Алтай сумын Засаг даргын Тамгын газарт 5.0 сая төгрөгийн, Дуут сумын Засаг даргын Тамгын газарт 5.0 сая төгрөгийн нийт 20.0 сая төгрөг /хорин сая/-ийн санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Тус өр барагдуулах санхүүгийн дэмжлэгт зарцуулах 20.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2021 онд батлагдсан төсвөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ